

## МОНГОЛБАНК-нд

## Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Цэрэндаваагийн ажлын тайлан

2023 оны 03 дугаар улирал

2023 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөрУлаанбаатар  
хот

Миний бие Н.Цэрэндаваа нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Мэдээллийн технологийн хорооны дарга, Аудитын болон Цалин урамшууллын хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлууд, Мэдээллийн технологийн хороо, Аудитын болон бусад хорооны хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	МТ хорооны хурал	Нийт оролцсон хурал
1.	-	5	3	1	9

Хурал хуралдсан огноогоор №2:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	МТ хорооны хурал
1.	-	2023-06-28 2023-07-03 2023-07-21 2023-07-28 2023-09-15	2023-07-04 2023-07-26 2023-08-25	2023-09-21

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал
1.	12	

Тайлант хугацаанд танхимаар буюу биечлэн оролцох 5 хуралд 100% ирцтэй, 3 удаа эчнээ санал хураалтаар, 1 удаа цахимаар Мэдээллийн технологийн хорооны хурлын даргаар ажиллаж, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн.

ТУЗ-ийн гишүүний хувьд:

1. Банкныг өөрчлөн байгуулах төлөвлөгөөний явцтай танилцаж үүрэг даалгавар өгөх,
2. Банкны 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэх,
3. ХЭ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
4. Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэх,

5. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдэх хөндлөнгийн аудитыг сонгон шалгаруулах тухай,
6. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх тайлагнах,
7. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам батлах,
8. Бусад хорооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр ТУЗ-ийн хуралд оролцлоо.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 12 удаагийн хэлцэлд саналаа өгсөн. Санал өгөөгүй хэлцэл байхгүй. 12 удаагийн зөрчил үүсэж болзошгүй хэлцлийг ангилж харуулбал:

1. Банкны үндсэн хөрөнгийн ашиглалтын гэрээний нөгөө тал нь банкны Хувьцаа эзэмшигч байх 1 тохиолдол
2. Банкны эрх бүхий албан тушаалтан зээл хүссэн 3 тохиолдол,
3. Холбоотой этгээдэд санал болгох зээлийн бүтээгдэхүүний нөхцөл батлах 2 тохиолдол,
4. Холбоотой этгээдээс бараа, ажил үйлчилгээ авах 2 тохиолдол,
5. Холбоотой этгээдтэй түрээсийн гэрээ байгуулах 4 тохиолдол тус тус байна.

Дээрх хэлцлүүд бүгд харьцуулсан судалгаатай ба сонирхлын зөрчилгүй гишүүд 100%-ийн саналтайгаар шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн дэргэдэх Мэдээллийн технологийн хорооны даргын хувьд:

1. Мэдээллийн технологийн хорооны үйл ажиллагааны журмыг батлуулав.
2. ISO27001 стандартыг банканд нэвтрүүлэхтэй холбоотойгоор зөвлөмжийг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газрын Мэдээллийн технологийн дотоод аудиторт өгсөн.
3. Bottom line Visa B2B үйлчилгээнд хамрагдах талаар Мэдээллийн технологийн болон Дижитал банкны газарт үүрэг чиглэл өгсөн.

Аудитын хорооны гишүүний хувьд:

1. Ариг банкны 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээний нөхцөл тохирох зэргээр ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд гүйцэтгэв.
2. СУГ-ын харьяа Төлбөр тооцооны хэлтсийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаанд 2017 оноос 2022 оны хугацаанд хамран хийсэн иж бүрэн шалгалтын тайлантай танилцаж зохих үүрэг даалгавар, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлав.
3. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газрын “Дүрэм”-ийг шинэчлэн, “Үйл ажиллагааны журам”-ыг шинээр батлав.
4. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газарт туршилтын хугацаагаар ажиллаж буй 2 аудиторын ажлын тайлантай танилцаж, үнэлэлт дүгнэлт гаргаж жинхэнэ ажилтан болгох саналыг ТУЗ-д хүргүүлсэн.

ТУЗ-н хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-н үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дэгийн дагуу, хүчин төгөлдөрт тооцогдох эсэхэд анхаарч ажилдаг.
- Монголбанкнаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг,

- ТУЗ-с засаж залруулах боломжтой асуудлууд байгаа тохиолдолд бид ТУЗ-н түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг өгдөг. Удирдлагын баг эдгээр хүсэлтийг дагаж мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТУЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-с гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс сайтар судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллахыг чармайж ирсэн болно.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, Мэдээллийн технологийн хорооны дарга,  
Аудитын болон Цалин, урамшууллын хорооны гишүүн



Н.Цэрэндаваа